



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ  
ДАРГА Д.ЦОГТБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.10.7 № 02/735

**Авлага барагдуулах тухай**

Засгийн газрын байруудын нэгдсэн захиргааны 2013 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн явцын аудитаар авлага барагдуулалтын байдлыг шалгахад: Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа анх 2010 оны 1 дүгээр сарын 01-нд байгуулагдсан ба эхлэлтийн балансаар Төрийн өмчийн хорооноос балансаас балансад 45,373,208 төгрөг 89 мөнгөний авлага шилжиж ирснээс 8,046,695 төгрөгийн авлага барагдаж, 37,326,513 төгрөг 89 мөнгөний авлага тодорхой нэр хаяг эзэнгүй гэдгээр авлага барагдуулах ажиллагаа зогсонги байдалд хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-ийн “Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгаадагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзэж дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Дээр дурдсан авлагыг тодруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, 2013 оны 12 дугаар сарын 01-ний дотор авлага барагдуулах арга хэмжээг авч ажиллах
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 12 дугаар 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн хороонд даалгаж байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР И.ТУЯА



070369